

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т. ЭНХБАЯР
ТАНАА

2021.02.25 № 07/494
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант 2020 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт тусгагдсан 6 зорилт, 29 арга хэмжээ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан 1 зорилтын 13 арга хэмжээ, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан 5 зорилтын 19 арга хэмжээ, нийт 12 зорилтын 61 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,190,974.61</u>	<u>29,330,070.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	28,190,974.61	29,330,070.00
354	Хангамжийн материал	28,190,974.61	29,330,070.00
35410	Бичиг хэргийн материал	1,218,004.61	242,000.00
35420	Аж ахуйн материал	2,577,700.00	1,853,300.00
35440	Түлш, шатах тослох материал	560,000.00	70,000.00
35470	Бусад хангамжийн материал	23,835,270.00	27,164,770.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>135,639,196.54</u>	<u>135,176,021.17</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	135,639,196.54	135,176,021.17
392	Биет хөрөнгө	133,345,863.24	133,195,354.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,808,060.00	97,027,360.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,723,881.05)	(36,089,161.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,009,309.00	87,547,909.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,412,291.41)	(18,573,019.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,824,000.00	3,824,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(159,333.30)	(541,733.22)
393	Биет бус хөрөнгө	2,293,333.30	1,980,666.61
39301	Програм хангамж	2,680,000.00	2,680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(386,666.70)	(699,333.39)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>163,830,171.15</u>	<u>164,506,091.17</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>163,830,171.15</u>	<u>164,506,091.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	163,830,171.15	164,506,091.17
512	Хуримтлагдсан үр дүн	163,830,171.15	164,506,091.17
51210	Өмнөх үеийн үр дүн	163,830,171.15	163,830,171.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>163,830,171.15</u>	<u>164,506,091.17</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	950,377,482.60	643,258,430.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	243,568,182.60	221,784,630.00
120	Нийтлэг татварын бус орлого	243,568,182.60	221,784,630.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	243,568,182.60	221,784,630.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	231,537,982.00	221,784,630.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,030,200.60	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	706,809,300.00	421,473,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	706,809,300.00	421,473,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	706,809,300.00	421,473,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	786,547,311.45	642,582,509.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,547,311.45	642,582,509.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	785,509,073.38	642,581,916.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,685,600.00	109,930,400.00
210101	Үндсэн цалин	70,303,500.00	79,300,900.00
210102	Нэмэгдэл	19,914,100.00	18,995,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,468,000.00	11,634,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,083,841.93	14,840,600.00
210201	Тэтгэврийн даатгал	8,218,200.00	10,443,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	966,899.98	1,099,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	773,500.00	879,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	200,475.14	219,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,924,766.81	2,198,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,799,600.00	34,500,000.00
210304	Байрны түрээс	17,799,600.00	34,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,927,971.00	19,460,354.61
210401	Бичиг хэрэг	11,608,629.00	6,361,954.61
210402	Тээвэр, шатахуун	13,882,452.00	8,384,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,436,890.00	4,714,300.00
2105	Нормативт зардал	39,690,050.00	9,240,000.00
210502	Хоол, хүнс	39,690,050.00	9,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	85,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	85,000.00
2107	Томилолт, зочны зардал	36,177,460.00	00.00
210702	Дотоод албан томилолт	36,177,460.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,114,000.00	103,686,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,114,000.00	103,686,130.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	488,030,550.45	350,839,431.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	461,950,546.39	305,774,256.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,039,800.00	20,844,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,040,204.06	24,221,075.37
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,038,238.07	593.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,238.07	593.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,238.07	593.62
213304	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	163,830,171.15	675,920.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	163,830,171.15	675,920.02

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	938,347,282.00	643,258,430.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	231,537,982.00	221,784,630.00
120	Нийтлэг татварын бус орлого	231,537,982.00	221,784,630.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	231,537,982.00	221,784,630.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	231,537,982.00	221,784,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	706,809,300.00	421,473,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	706,809,300.00	421,473,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	797,698,082.00	619,500,530.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	797,698,082.00	619,500,530.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,659,843.93	619,499,936.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,685,600.00	109,930,400.00
210101	Үндсэн цалин	70,303,500.00	79,300,900.00
210102	Нэмэгдэл	19,914,100.00	18,995,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,468,000.00	11,634,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,083,841.93	14,840,600.00
210201	Тэтгэврийн даатгал	8,218,200.00	10,443,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	966,899.98	1,099,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	773,500.00	879,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	200,475.14	219,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,924,766.81	2,198,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,799,600.00	34,500,000.00
210304	Байрны түрээс	17,799,600.00	34,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,250,452.00	18,002,900.00
210401	Бичиг хэрэг	10,448,000.00	5,394,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,442,452.00	7,894,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,360,000.00	4,714,300.00
2105	Нормативт зардал	39,690,050.00	9,240,000.00
210502	Хоол, хүнс	39,690,050.00	9,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,372,440.00	642,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,052,440.00	642,500.00
210602	Тавилга	320,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	36,177,460.00	00.00
210702	Дотоод албан томилолт	36,177,460.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,060,000.00	112,342,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,060,000.00	112,342,130.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	496,540,400.00	320,001,406.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	486,540,400.00	297,607,306.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,000,000.00	22,394,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,038,238.07	593.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,238.07	593.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,238.07	593.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	140,649,200.00	23,757,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	140,649,200.00	23,757,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	140,649,200.00	23,757,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	140,649,200.00	23,757,900.00

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба. 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

222001	Тоног төхөөрөмж	00.00	12,219,300.00
223001	Бусад хөрөнгө	00.00	11,538,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	140,649,200.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-140,649,200.00	-23,757,900.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	163,830,171.15	163,830,171.15
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	163,830,171.15	163,830,171.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	675,920.02	675,920.02
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,506,091.17	164,506,091.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,473,800.00	421,473,206.38	593.6	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,473,800.00	421,473,206.38	593.6	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,473,800.00	421,473,206.38	593.6	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,930,400.00	109,930,400.00	0.0	100.0
210101	Үндсэн цалин	79,300,900.00	79,300,900.00	0.0	100.0
210102	Нэмэгдэл	18,995,100.00	18,995,100.00	0.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,634,400.00	11,634,400.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,840,600.00	14,840,600.00	0.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	10,443,400.00	10,443,400.00	0.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,099,300.00	1,099,300.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	879,500.00	879,500.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	219,800.00	219,800.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,198,600.00	2,198,600.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,500,000.00	34,500,000.00	0.0	100.0
210304	Байрны түрээс	34,500,000.00	34,500,000.00	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	16,577,900.00	16,577,900.00	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	3,969,500.00	3,969,500.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	7,894,100.00	7,894,100.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,714,300.00	4,714,300.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,118,700.00	11,118,700.00	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,118,700.00	11,118,700.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	228,312,100.00	228,311,506.38	593.6	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	228,312,100.00	228,311,506.38	593.6	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,194,100.00	6,194,100.00	0.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	421,473,800.00	421,473,800.00	0.0	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	421,473,800.00	421,473,800.00	0.0	100.0

131007	Улсын төсвөөс санхүүжих	421,473,800.00	421,473,800.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	13	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		221,784,630.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		221,784,630.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		221,784,630.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,425,000.00
210401	Бичиг хэрэг		1,425,000.00
2105	Нормативт зардал		9,240,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		00.00
210502	Хоол, хүнс		9,240,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		112,342,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		112,342,130.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		98,777,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		82,577,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		16,200,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		221,784,630.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		221,784,630.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		221,784,630.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн захирагч Т.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зардлын нормыг мөрдөж үр ашиггүй зардал давтан гаргахгүй байх, шилэн дансны мэдээллийг байршуулахдаа хугацаа хоцроохгүй байх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний 184 дүгээр тогтоолыг мөрдөөгүгээс үр ашиггүй зардал

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг холбогдох санхүүгийн мэдээ тайлангуудтай тулган шалгахад үнэн зөв илэрхийлсэн ч хугацаандаа мэдээлэх тоон давтамжаараа 15 удаа хугацаа хоцорсон байна

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар Ол дөш хайрхан аудит ХХК аудитын менежер Т.Сарантуяа, аудитор Ц.Бумцэнд нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ол дөш хайрхан аудит ХХК-д 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 3/11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба нь *“Жендерийн тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон хөгжлийн зорилтод хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс гаргасан үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад оршино.”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Жендэрийн тэгш байдлыг хангах тухай, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд Жендерийн үндэсний хорооны дүрэм, Жендэрийн үндэсний хорооноос гаргасан тогтоол, шийдвэр, бусад холбогдох хууль, журмыг хангах зорилтуудын хүрээнд дараах үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна Үүнд:

- Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;
- Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх;
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт;
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний чадавхыг бэхжүүлэх;

- Хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх ;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл хоёр хувиар нэмэгдсэн.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгож эхэлсэн байна.
- 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 323 дугаар тогтоолын 2 дахь заалтын жендэрийн үндэсний хорооны ажлын албаны орон тооны хязгаарыг “8” гэснийг 2020 оны 3 дугаар сарын 4-ний Засгийн газрын 80 дугаар тогтоолоор “14” гэж өөрчлөн баталжээ.
- Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ний 227 дугаар тогтоолоор Жендэрийн Үндэсний хорооны дүрмийг шинэчлэн баталсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тус ажлын албан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

2020 оны Ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд татвар, нийгмийн даатгалын байгууллагаас шалгалт хийгдээгүй байна.

ЗГХЭГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газраас шилэн дансанд дотоод аудит хийсэн бөгөөд ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 938,347.3 мянган төгрөгөөс тооцон 9,383.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлсон.

Гүйцэтгэлийн шатанд дахин хянаж материаллаг байдлын түвшнийг тооцохдоо суурийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар тооцож 6,425.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жендэрийн үндэсний хорооны Ажлын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 463.2 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Бараа материал	28,190.9	29,330.0	1,139.1
Үндсэн хөрөнгө	135,639.2	135,176.0	(463.2)
Нийт хөрөнгө	163,830.1	164,506.0	675.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	163,830.1	164,506.1	675.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	163,830.1	164,506.1	675.9

Мөнгөн хөрөнгө, авлага данснууд тайлант онд үлдэгдэлгүй гарсан болно.

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 29,330.0 мянган төгрөг болж 1,139.1 мянган төгрөгөөр өссөн нь 84,338,7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 83,199,6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 29,330.0 мянган төгрөгийн хөрөнгө нь ашиглалтад байгаа хөрөнгүүд байна.

Оны эцэст үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 135,176.0 мянган төгрөг болж 463.2 мянган төгрөгөөр буурсан нь 23,757.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, тайлант хугацаанд 24,221.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Биет бус хөрөнгийн дүн 312.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлийн дүнгээс шалтгаалжээ.

Өр төлбөр данс тайлант онд үлдэгдэлгүй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 164,506.1 мянган төгрөг болж 675.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал дансны үлдэгдэл 1,139.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 463.2 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Энэ нь нийт хөрөнгийн хэмжээ болон засгийн газрын оролцооны эх үүсвэрийг 675.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 706,691.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 706,691.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 285,218.0 мянган төгрөгөөр бууруулсан материаллаг өөрчлөлт нь 2017-2021 онд хэрэгжүүлэх Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр дуусаж байгаатай уялдан өмнөх оны баталсан төсвөөс буурчээ.

Тайлант 2020 онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт тусгагдсан 6 зорилт, 29 арга хэмжээ, ЖЭТБХангах тухай хуульд заасан 1 зорилтын 13 арга хэмжээ, Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан 5 зорилтын 19 арга хэмжээ, нийт 12 зорилтын 61 арга хэмжээг санхүүжүүлэхээр 421,473.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 421,473.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 421,473.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421,473.2 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлдэг төслийн “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” MNG06NCGE төслийн санхүүжилт 211,182.6 мянган төгрөг, Жендэрийн Үндэсний Хороо, Азийн сангаас Канадын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх” төслөөс 10,602.0 мянган төгрөг нийт 221,784.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилт авч хангамж, бараа материалын зардалд 1,425.0 мянга, нормативт зардалд 9,240.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 112,342.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 82,577.5 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 16,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 103 мэдээллээс 88 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,935.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 5,935.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолд заасан цахим хуудсанд байршуулбал зохих 103 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хугацаанд бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5.935.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний Суудлын авто машины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 184 дүгээр тогтоолын 2; Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний Суудлын авто машины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 184 дүгээр тогтоолын 8-ийг тус тус зөрчиж, шатахууны зардлыг 5,935.2 мянган төгрөгөөр хэтрүүлж үр ашиггүй зардал гаргажээ.

1.1 Эрсдэл:

Шатахууны зардлыг хэтрүүлэх

1.2 Өгсөн зөвлөмж:

Цаашид авто машины цилиндрийн багтаамж 2500 см³ –ээс илүүгүй байх, ажлын хоногт дунджаар 40 км-ээс хэтрүүлэхгүй байх.

Үр ашиггүй зардал гаргахгүй байх,

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид үр ашиггүй зардал давтан гаргахгүй, Засгийн газрын дээрхи тогтоолын холбогдох заалтыг мөрдөж ажиллана гэжээ

2. Шилэн дансны хэрэгжилт

2.1 Илрүүлэлт

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг холбогдох санхүүгийн мэдээ тайлангуудтай тулган шалгахад мэдээлэх давтамж 103 байхаас 95 удаа хугацаандаа байршуулж, мэдээлсэн. Харин хугацаа хоцроож байршуулсан 8 мэдээлэл байна.

2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хугацааг хоцроосон

2.3 Албан шаардлага өгсөн

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020 он			САГ-2021-10-СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Жендэрийн Үндэсний хорооны Ажлын алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Засгийн газрын тогтоолыг мөрдөөгүй илүү шатахуун зарцуулсан зөрчил	5,935.2	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Т.Энхбаяр Б.Гантуяа
2	Шилэн дансны зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.		Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	Т.Энхбаяр Б.Гантуяа
ДҮН		5,935.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 139/40160062
СЯГ-2021/10/СТЯ-ТЧЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жендэрийн үндэсний хороо Ажлын албаны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 15 мэдээлэл байршуулахаас 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1.-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ," 6.4.1-д "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт," 6.4.2-д "Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт," 6.4.3-д "Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл", 6.4.4-д "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг", 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" 6.4.6-д "Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн", 6.4.7-д "Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт", 6.4.8-д "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн


ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, байршуулж, биелэлтийг 2020 байгаа дээрхи зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хугацаанд нь байршуулан хэрэгжүүлж ажиллахыг Жендэрийн Үндэсний хорооны Ажлын албаны дарга Т.Энхбаяр, нягтлан бодогч Б.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ГАЗРЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

“ОЛ ДӨШ ХАЙРХАН АУДИТ” ХХК –ИЙН
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Ц.БУМЦЭНД

[illegible]

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.